# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ – 2025 ОН

ЗОХИЦУУЛАЛТТАЙ САЛБАРЫН НЭГДСЭН СУДАЛГАА

(ДААТГАГЧ, ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ, ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ)


**Гүйцэтгэсэн:**

А.Авир, хэлтсийн дарга
Л.Мөнхзаяа, ахлах референт
Ж.Лхагвамядаг, мэргэжилтэн
Б.Арьяаманал, мэргэжилтэн



Компанийн засаглал, комплайнсын хэлтэс

2026 он

# ЗОХИЦУУЛАЛТТАЙ САЛБАРЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ - 2025 ОН

## 1. ҮЙЛ ЯВЦЫН ӨРНӨЛ

**2006 он**

Монгол Улсын Их Хурлаас “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийг баталж, компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох бүрэн эрхийг тус Хороонд олгов.

**2007 он**

“Монгол компанийн засаглалын кодекс”-ийг Хороо анх удаа батлав.

**2014 он**

“Компанийн засаглалын кодекс”-т нэмэлт, өөрчлөлтийг оруулав.

**2022.03.23**

Хорооны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийн шинэчилсэн найруулга батлагдлаа. Шинэчилсэн кодексийн хавсралтаар олон улсад түгээмэл ашиглагддаг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмаар үнэлгээний аргачлал бүхий тайлангийн маягт болон компанийн дотооддоо баталж, мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмын зааврын үлгэрчилсэн загваруудыг батлав.

**2022.04.15**

Кодекс “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгэгдэж, эрх зүйн мэдээллийн www.legalinfo.mn нэгдсэн системд байршсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба нээлттэй хувьцаат компани (ХК), даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болон хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) дагаж мөрдөх үүргийг хүлээв.

**2022.04.20**

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт 116 зохицуулалттай этгээдийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагуудыг оролцуулан кодексийн хэрэгжилтийн үнэлгээг хэрхэн тайлагнах талаар сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

**2022.05.16**

Зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн кодексийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг эхлүүлэв.

**2022.06.22**

Хорооны даргын 2022 оны 336 дугаар тушаалаар “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийг баталж, компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх нэгдсэн зохион байгуулалт, зах зээлд оролцогч талуудын баримтлах зарчим, чиг үүргийг тодорхойлов.

**2022.12.30**

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт 116 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг үнэлэн тайлангийн хариугаар заавар зөвлөмж, эсхүл хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь тооцон салбар тус бүрийн хэрэгжилтийн үнэлгээний дүнг нэгтгэн нийтэд мэдээлэв. Үнэлгээг хянан баталгаажуулахад, 2022 оны наймдугаар сарын байдлаар кодексийн хэрэгжилтийн анхны буюу нөхцөл байдлын үнэлгээ **55.3** хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, мөн оны 12 дугаар сард биелэлтийг нь тооцсон давтан үнэлгээгээр зохицуулалттай 3 салбарын кодексийн хэрэгжилт дунджаар **16.4** нэгж хувиар өсөв.

**2023.06.30**

Хорооны зохицуулалттай нийт 124 этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн үнэлгээг хийж, компани тус бүрд хугацаатай үүрэг даалгавар өгөв.

**2023.12.28**

Нийт 124 тусгай зөвшөөрөлтэй компани (Даатгагч, ББСБ, ХОМК)-ийн кодексийн хэрэгжилтийг хянан баталгаажуулахад 2023 оны эцсийн байдлаар дундаж үнэлгээ 2022 оныхоос **30** гаруй нэгж хувиар дээшилсэн дүн гарав.

**2024.10.15**

Хорооны зохицуулалттай Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ) 12 компанийн кодексийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг эхлүүлэв.

**2025.01.20**

Хорооны зохицуулалттай 152 этгээд (Даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ)-ийн хэрэгжилтийн үнэлгээ 2024 оны эцсийн байдлаар **79.9** хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад **3.3** нэгж хувиар өсөв. 2024 оны жилийн эцсийн байдлаар тайлангаа ирүүлсэн 113 компанийн давтан үнэлгээг хянан баталгаажуулахад, кодексийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ **85.5** хувьд хүрчээ.

**2025.12.31**

Хорооны зохицуулалттай 160 этгээдийн (Даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ)-ийн "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн үнэлгээ 2025 оны эцсийн байдлаар **77.8** хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад **2.1** нэгж хувиар буурав. 2025 оны жилийн эцсийн байдлаар тайлангаа ирүүлсэн 114 компанийн давтан үнэлгээг хянан баталгаажуулахад, кодексийн хэрэгжилтийн жилийн дундаж үнэлгээ **81.6** хувьд хүрэв.

## 2. СУДАЛГААНЫ ТАЛААР

Компанийн засаглалыг нэвтрүүлэх нь бизнесийн үйл ажиллагааны урт хугацааны өгөөжийг хангах төдийгүй хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд суурилсан шударга, нээлттэй зах зээлийн орчин бүрдэхэд эргээр нөлөөлдөг тул нийгэмд ач холбогдолтой энэ сэдвийг онцгойлон анхаарч, тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

Кодексийн хэрэгжилтийг үнэлэхдээ Хорооны даргын 2022 оны 336 дугаар тушаалын хавсралтаар “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамжид заасан аргачлалыг ашиглав.

## 3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

- “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж нэгдсэн тайлан боловсруулах;
- компанийн засаглалын хандлага, учирч болох эрсдэлийг тодорхойлох;
- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч эрсдэлийн үнэлгээ хийж, шийдвэр гаргах засаглалын үзүүлэлтийг бий болгох;
- зохицуулалттай этгээд өөрийн засаглалыг салбартаа харьцуулах, сайжруулахад чиг баримжаа болох компанийн засаглалын жишгийг тодорхойлох;
- хууль тогтоомж болон компанийн баталсан дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журмын эрх зүйн орчныг оновчтой болгож, сайжруулах;
- хугацааны цуваа хэлбэрээр статистик мэдээллийг үүсгэх.

## 4. АРГАЧЛАЛ

Судалгаа нь “Компанийн засаглалын кодекс”-ийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуумжаар 160 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ)-ийн анхны үнэлгээ, 114 компанийн давтан үнэлгээ болон Хорооноос хэрэгжүүлсэн судалгааны үр дүнд суурилсан.

### 4.1. СУДАЛГААНЫ ГОЛЛОХ СЭДЭВ:

**а. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагаа, бүтэц, бүрэлдэхүүн.**

**б. дотоод эрх зүйн зохицуулалтын ил тод байдал /цахим хуудасны шинэчлэл/:**

- бодлогын баримт бичиг;
- ёс зүйн дүрэм;
- компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны журам;
- мэдээллийн ил тод байдал, тайлагнал, комплайнсын хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны журам, заавар;
- компанийн эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр.

**в. хамгийн сайн болон сул хэрэгжсэн засаглалын үзүүлэлтүүд.**

### 4.2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН:

Кодексийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн зохицуулалттай этгээд (Даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ).

а. Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс нийт 160 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК, ВХҮҮ)-ийн суурь үнэлгээг хийж, тайлангийн хариугаар хугацаатай

үүрэг бүхий албан тоот хүргүүлснээр нийт 114 компанийн давтан зайны үнэлгээг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлэв.

б. Компаниудын ирүүлсэн зайны үнэлгээг хавсаргасан нотлох баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцов.

в. Үнэлгээний нэгдсэн дүнг үндэслэн компани тус бүрд тухайлсан зөвлөмж, чиглэл хүргүүлэн тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлов.

Компанийн үнэлгээний нэгдсэн дүн нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэл хийхтэй холбоотойгоор Хорооноос холбогдох шийдвэр гаргах, компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй, оновчтой болгох чиглэлд дүн шинжилгээ хийх, мөн кодексийн хэрэгжилтийн нэгдсэн судалгааг гарган нийтлэх, мэдээллийн зорилгоор ашиглагдана.

## 5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

*ДҮРСЛЭЛ 1. ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:*




*Шигтгээ 1:*

*Кодексийн тайлбар хэсэгт заасан ТУЗ, түүний дэргэдэх хороод, дарга, гишүүдийн ажлын тайлан, гүйцэтгэлийн үнэлгээнд тавигддаг зөвлөмжүүдийг заавал дагаж мөрдөх шаардлага болгон кодексийн үнэлгээний аргачлалд 2 нэмэлт тохируулга (ТУЗ-ийн жилийн ажлын тайлан, ТУЗ-ийн дарга, гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ)-ыг оруулан, тус бүр нэг оноогоор үнэлж, комплайнсын хяналтыг хэрэгжүүлж эхлэв. Үүний зэрэгцээ 2025 онд холбогдох салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан компаниудын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн анхны нөхцөл байдалд үнэлгээг хийсэн нь дундаж үнэлгээнд нөлөөлөв. Тухайлбал, анхны нөхцөл байдлын үнэлгээ нь хэрэгжилтийн эхний түвшинг илэрхийлдэг тул харьцангуй доогуур үнэлэгдсэнээр нийт 160 компанийн 2025 оны жилийн эцсийн дундаж үнэлгээ өмнөх үеийнхээс 2.1 нэгж хувиар буурав.*

*ДҮРСЛЭЛ 2. ХУГАЦААТАЙ ЧИГЛЭЛ, ҮҮРГЭЭР “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:*




*Шигтгээ 2:*

*2025 оны жилийн эцсийн байдлаар тайлангаа шинэчлэн ирүүлсэн 114 зохицуулалттай этгээдийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ өмнөх оны мөн үеийнхээс дунджаар 3.9 нэгж хувиар буурав*

*Шигтгээ 3:*

*2025 оны жилийн эцсийн байдлаар тайлангаа шинэчлэн ирүүлсэн 114 компанийн даатгагчийн үнэлгээ өмнөх оны мөн үеийнхээс дунджаар 1.6, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага 4.8, хөрөнгө оруулалтын менежментийн компани 8.0, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч компани 1.1 нэгж хувиар тус тус буурчээ*

*ДҮРСЛЭЛ 3. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ (Зохицуулалтын салбарын 160 компани):*



*ДҮРСЛЭЛ 4. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ:*




*ДҮРСЛЭЛ 5. ЦАХИМ ХУУДСАНДАА ИЛ БОЛГОСОН МЭДЭЭЛЭЛ:*




*ДҮРСЛЭЛ 6. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛД ХИЙГДСЭН ТОХИРУУЛГА БУЮУ ШААРДЛАГА:*



## 6. ДААТГАГЧИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 7. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ:*




*Шигтгээ 4:*

*Нийт* ***21*** *даатгагчийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад* ***1.6*** *нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 8. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ:*




*Шигтгээ 5:*

*ТУЗ нь хувьцаа эзэмшигчийн эрхийг тэгш хангах, компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангах зэрэг ажлуудыг хангалттай сайн зохион байгуулсан гэж үнэлэгдсэн бол ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн жилийн үйл ажиллагаар ач холбогдлоор нь зохистой байдлаар төлөвлөх, жилийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх зэрэг ажлууд хангалтгүй байв*

ДҮРСЛЭЛ 9. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН:




*Шигтгээ 6:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 5-9 гишүүнтэй, үүнээс 31.3% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 7:*

*Нийт төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 34.1 хувийг эмэгтэй гишүүд эзэлж байна.*

ДҮРСЛЭЛ 10. ТУЗ-ИЙН ХУРАЛ:

| Он | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|
| ТУЗ-ийн хурлын дундаж тоо | 8 | 17 | 15 | 14 |
| Хурлын дундаж ирц | 98% | 95% | 96% | 97% |
| Хэлэлцсэн асуудлын дундаж тоо | 3 | 30 | 54 | 46 |

*ДҮРСЛЭЛ 11. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 12. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*

| | |
|---|---|
| 2022.IV | • Хүйс-эмэгтэй дундаж - **98.0%**<br>• Мэргэжил-эрх зүйч дундаж - **90.0%**<br>• ТУЗ-ийн нарийн бичгийн даргын дундаж нас - **31** |
| 2023.IV | • Хүйс-эмэгтэй дундаж **-50.0%**<br>• Мэргэжил-эрх зүйч дундаж - **38.0%**<br>• ТУЗ-ийн нарийн бичгийн даргын дундаж нас - **33** |
| 2024.IV | • Хүйс-эмэгтэй дундаж - **45.0%**<br>• Мэргэжил-эрх зүйч дундаж - **27.0%**<br>• ТУЗ-ийн нарийн бичгийн даргын дундаж нас - **33** |
| 2025.IV | • Хүйс-эмэгтэй дундаж - **44.3%**<br>• Мэргэжил-эрх зүйч дундаж - **41.8%**<br>• ТУЗ-ийн нарийн бичгийн даргын дундаж нас - **43** |

*ДҮРСЛЭЛ 13. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ:*



*ДҮРСЛЭЛ 14. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*




*ДҮРСЛЭЛ 15. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 8:*

*Төлөвлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 3-5 гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 16. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*



*Шигтгээ 9:*

*2025 оны байдлаар* **90.0%** *нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаа өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 10:*

*Тайлант хугацаанд* **85.0%** *нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 17. КОДЕКСИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*



## 6.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН*† *(Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав)*

| № | Компанийн нэрс | Үнэлгээ |
|---|---|---|
| 1 | "АГУЛА ДААТГАЛ" ХХК | 98.6% |
| 2 | "ПРАКТИКАЛ ДААТГАЛ" ХХК | 98.6% |
| 3 | "МӨНХ ДААТГАЛ" ХХК | 97.2% |
| 4 | "ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ" ХК | 97.2% |
| 5 | "ГАН ЗАМ ДААТГАЛ" ХХК | 95.8% |
| 6 | "МОНРЕ ДААТГАЛ" ХХК | 95.8% |
| 7 | "МИГ ДААТГАЛ" ХХК | 94.4% |
| 8 | "НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ" ХХК | 93.1% |
| 9 | "УЛААНБААТАР ХОТЫН ДААТГАЛ" ХХК | 91.7% |
| 10 | "ХААН ДААТГАЛ" ХХК | 88.9% |
| 11 | "МАНДАЛ ЛАЙФ ДААТГАЛ" ХХК | 87.5% |
| 12 | "НОМИН ДААТГАЛ" ХХК | 87.5% |
| 13 | "АМАР ДААТГАЛ" ХХК | 86.1% |
| 14 | "АГИС МЕНЕЖМЕНТ ДААТГАЛ" ХХК | 84.7% |
| 15 | "ИНШҮРКО ДААТГАЛ" ХХК | 83.3% |
| 16 | "КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ" ХХК | 65.3% |
| 17 | "ҮНДЭСТЭН ЖЕНЕРАЛ ДААТГАЛ" ХХК | 56.9% |

* “Ард даатгал” ХК, “Бодь даатгал” ХК, “Мандал даатгал” ХК, “Монгол даатгал”, “Тэнгэр даатгал” ХК-уудын хэрэгжилтийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн кодексийн үнэлгээний тайланд тусгав.

† “Коннектлайф даатгал” ХХК болон “Үндэстэн женерал даатгал” ХХК-ууд нь даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 онд авсан бөгөөд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайлангийн анхны нөхцөл байдлын үнэлгээг 2026 оны 2 дугаар улиралд багтаан хэрэгжилтийн тайланг ирүүлэх даалгавар өгөгдсөн.

## 7. ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 18. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ:*




*Шигтгээ 11:*

*Нийт итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч 66 ББСБ-ын кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад үнэлгээ 4.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 19. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ:*




*Шигтгээ 12:*

*ТУЗ нь компанийн бизнесийн ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх, комплайнсын хяналтыг зохистой хараат бус байдлаар хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хангалттай сайн зохион байгуулсан гэж үнэлэгдсэн бол ТУЗ-ийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллыг үйл ажиллагааны тайланд тусгах, оролцогч талуудтай харилцах, мэдээлэл солилцох, ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэлийн үр дүнгээ үнэлэх зэрэг ажлууд хангалтгүй хийгдсэн байв*

*ДҮРСЛЭЛ 20. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 13:*

*Төлөөлөн удирдах зөвлөл нь 3-9 хүний бүрэлдэхүүнтэйгээс 28.0% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 14:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 33.3% нь эмэгтэй.*

*ДҮРСЛЭЛ 21. ТУЗ-ИЙН ХУРАЛ:*

| Он | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|
| ТУЗ-ийн хурлын дундаж тоо | 8 | 7 | 12 | 14 |
| Хурлын дундаж ирц | 98% | 94% | 90% | 94% |
| Хэлэлцсэн асуудлын дундаж тоо | 3 | 9 | 15 | 18 |

*ДҮРСЛЭЛ 22. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 23. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*




*ДҮРСЛЭЛ 24. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ:*



*ДҮРСЛЭЛ 25. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*




*ДҮРСЛЭЛ 26. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 15:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар* 3-5 *гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 27. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*



*Шигтгээ 16:*

*2025 оны байдлаар* **90.0%** *нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаа өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 17:*

*Тайлант хугацаанд* **76.0%** *нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 28. КОДЕКСИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*




## 7.1. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН[‡] *(Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав)*

| № | Компанийн нэрс | Үнэлгээ | № | Компанийн нэрс | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | "БУЛЛ КАПИТАЛ ББСБ" ХХК | 98.6% | 44 | "ДИ ЭМ ФИНАНС ББСБ" ХХК | 80.6% |
| 2 | "СЭНД ЭМ ЭН ББСБ" ХХК | 98.6% | 45 | "МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ" ХХК | 80.6% |
| 3 | "ХАТАН СУУДАЛ ИНВЕСТ ББСБ" ХХК | 98.6% | 46 | "НОРБУ ББСБ" ХХК | 79.2% |
| 4 | "ПОКЕТ ББСБ" ХХК | 98.6% | 47 | "МӨНХ ОРШИХ КАПИТАЛ ББСБ" ХХК | 76.4% |
| 5 | "БУМАН ДУСАЛ ББСБ" ХХК | 97.2% | 48 | "ТЭЛМЭН ХАС ББСБ" ХХК | 76.4% |
| 6 | "ГАРЬД КАПИТАЛ ББСБ" ХХК | 97.2% | 49 | "СЭКЮР ФИНАНС ББСБ" ХХК | 75.0% |
| 7 | "АБТС ББСБ" ХХК | 95.8% | 50 | "АШИД ГОЛОМТ ББСБ" ХХК | 73.6% |
| 8 | "БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК | 95.8% | 51 | "АШИД КАПИТАЛ ББСБ" ХХК | 73.6% |
| 9 | "БСБ ФИНАНС ББСБ" ХХК | 95.8% | 52 | "ХӨГЖИЛ ФИНАНС ББСБ" ХХК | 73.6% |
| 10 | "ГЭРЭЛ ФИНАНС ББСБ" ХХК | 95.8% | 53 | "АЛТАН ЗООС КАПИТАЛ ББСБ" ХХК | 72.2% |
| 11 | "НЭТ КАПИТАЛ ФИНАНС КОРПОРАЦИ ББСБ" ХХК | 95.8% | 54 | "МОНГОЛЖИН ВЕНЧУР КАПИТАЛ ББСБ" ХХК | 70.8% |

[‡] "Ард кредит ББСБ" ХК, "Инвескор ББСБ" ХК, "Лэндмн ББСБ" ХК, "Сэндли ББСБ" ХК, "Тандэм инвест ББСБ" ХК-уудын хэрэгжилтийг "Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн кодексийн үнэлгээний тайланд тусгав.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | "СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 95.8% | 55 | "ҮНЭТ КРЕДИТ ББСБ" ХХК | 70.8% |
| 13 | "ФРАНКФУРТ КАПИТАЛ ББСБ" ХХК | 95.8% | 56 | "ЭНХФАЙНАНС ББСБ" ХХК | 70.8% |
| 14 | "ОМНИ КАПИТАЛ ББСБ" ХХК | 94.4% | 57 | "ДЕВЕЛОПИНГ ЭНТЕРПРЕНЮРИАЛ МОНГОЛИА ББСБ" ХХК | 69.4% |
| 15 | "ҮЙЗЭН-ИВЭЭЛТ ББСБ" ХХК | 94.4% | 58 | "ТИТЭМ КАПИТАЛ ББСБ" ХХК | 69.4% |
| 16 | "ЖИ ЭС БИ КАПИТАЛ ББСБ" ХХК | 93.1% | 59 | "ХАС ХААН ББСБ" ХХК | 69.4% |
| 17 | "ПРОГРЕСС КАПИТАЛ ББСБ" ХХК | 93.1% | 60 | "ХӨТӨЛТНОМГОН ББСБ" ХХК | 69.4% |
| 18 | "СОЛОНГО КАПИТАЛ ББСБ" ХХК | 93.1% | 61 | "КРЕДИТЕХ СТМ ББСБ" ХХК | 68.1% |
| 19 | "БҮРЭНФИНАНС ББСБ" ХХК | 91.7% | 62 | "ДОТНО ФИНАНС ББСБ" ХХК | 66.7% |
| 20 | "МИКРОКРЕДИТ ББСБ" ХХК | 91.7% | 63 | "НАНОКАПИТАЛ ББСБ" ХХК | 65.3% |
| 21 | "НӨМӨР КРЕДИТ ББСБ" ХХК | 91.7% | 64 | "АКСИС КАПИТАЛ ББСБ" ХХК | 63.9% |
| 22 | "СОНО ФИНТЕК ББСБ" ХХК | 91.7% | 65 | "МОНГОЛИАНМОРТГЭЙЖ ФАНД ББСБ" ХХК | 62.5% |
| 23 | "ТАВАН БОГД ФИНАНС ББСБ" ХХК | 91.7% | 66 | "ГАЗАР КАПИТАЛ ПАРТНЕРС ББСБ" ХХК | 61.1% |
| 24 | "ФИНРҮҮТ-ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 91.7% | 67 | "ЭКСИМ КАПИТАЛ ББСБ" ХХК | 59.7% |
| 25 | "ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ" ХХК | 90.3% | 68 | "АНДУУД ФИНАНС ББСБ" ХХК | 58.3% |
| 26 | "ЗӨГИЙ САНХҮҮГИЙН ГРУПП ББСБ" ХХК | 90.3% | 69 | "ИХ ЭРИН КАПИТАЛ ББСБ" ХХК | 56.9% |
| 27 | "МАГНА ПРОФИТ ЭНД ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 90.3% | 70 | "ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ" ХХК | 56.9% |
| 28 | "ЗЭЭЛ ЭМ ЭН ПЛАТФОРМ ББСБ" ХХК | 88.9% | 71 | "ӨЛЗИЙТ ФИНАНС ББСБ" ХХК | 56.9% |
| 29 | "ИХ ИРЭЭДҮЙ КАПИТАЛ ББСБ" ХХК | 88.9% | 72 | "ТРАНСКАПИТАЛ ББСБ" ХХК | 56.9% |
| 30 | "КИНГДОМ ИНВЕСТ ББСБ" ХХК | 88.9% | 73 | "МОНГОЛЫН САНХҮҮГИЙН ГРУПП ББСБ" ХХК | 55.6% |
| 31 | "ТРАСТ ФИНАНС ББСБ" ХХК | 88.9% | 74 | "ЦЭГЦ ХӨРӨНГӨ ББСБ" ХХК | 55.6% |
| 32 | "ФИНКО КАПИТАЛ ББСБ" ХХК | 88.9% | 75 | "ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ИНВЕСТ ББСБ" ХХК | 52.8% |
| 33 | "ЭКО КРЕДИТ ББСБ" ХХК | 88.9% | 76 | "ХААН КРЕДИТ ББСБ" ХХК | 51.4% |
| 34 | "АНЛОК КАПИТАЛ ББСБ" ХХК | 87.5% | 77 | "ШИЙДЭЛ ФИНАНС ББСБ" ХХК | 51.4% |
| 35 | "АЛЛИАНС КАПИТАЛ ББСБ" ХХК | 87.5% | 78 | "НОМИН ЮНИТИ ББСБ" ХХК | 50.0% |
| 36 | "БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС ББСБ" ХХК | 87.5% | 79 | "ЭНТ КРЕДИТ ИНВЕСТМЕНТ ББСБ" ХХК | 50.0% |
| 37 | "ГОЛДЕН ХИЛЛ ПАРТНЕРС ББСБ" ХХК | 87.5% | 80 | "ЕСӨН ФИНАНС ББСБ" ХХК | 48.6% |
| 38 | "БЭРС ФИНАНС ББСБ" ХХК | 84.7% | 81 | "ИНВЕСТОС ББСБ" ХХК | 37.5% |
| 39 | "ЭН ВИ СИ ББСБ" ХХК | 84.7% | 82 | "ЦЕНТРАЛ КАПИТАЛ ББСБ" ХХК | 23.6% |
| 40 | "МАНДАЛ ДИЖИТАЛ КРЕДИТ ББСБ" ХХК | 83.3% | 83 | "ГРИЙН ФИНТЕК ББСБ" ХХК | 19.4% |
| 41 | "ДАРЬ ФИНАНС ББСБ" ХХК | 81.9% | 84 | "ДЭВЖИХ НЭХИЙ ББСБ" ХХК | 18.1% |
| 42 | "ЖЭТФИНАНС ББСБ" ХХК | 81.9% | 85 | "УДАМ ФИНАНС ББСБ" ХХК | 15.3% |
| 43 | "МОБИФИНАНС ББСБ" ХХК | 81.9% | 86 | "ТЭНГЭРЛИГ АВТО ФИНАНС ББСБ" ХХК | 13.9% |

# 8. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИУДЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 29. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ:*




*Шигтгээ 18:*

*Нийт хөрөнгө оруулалтын менежментийн* ***16*** *компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад үнэлгээ* ***8.0*** *нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 30. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ:*




*Шигтгээ 19:*

*ТУЗ нь бизнесийн ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх, хувьцаа эзэмшигчийн эрхийг тэгш хангах зэрэг ажлуудыг хангалттай сайн зохион байгуулсан гэж үнэлэгдсэн бол ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааг ач холбогдлоор нь зохистой байдлаар төлөвлөх, жилийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх зэрэг ажлууд хангалтгүй байв*

*ДҮРСЛЭЛ 31. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 20:*

*Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 гишүүнтэйгээс 33.3% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 21:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 34.0% нь эмэгтэй.*

*ДҮРСЛЭЛ 32. ТУЗ-ИЙН ХУРАЛ:*

| Он | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|
| ТУЗ-ийн хурлын дундаж тоо | 5 | 4 | 5 | 5 |
| Хурлын дундаж ирц | 96% | 92% | 95% | 96% |
| Хэлэлцсэн асуудлын дундаж тоо | 2 | 8 | 6 | 6 |

*ДҮРСЛЭЛ 33. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 34. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*




*ДҮРСЛЭЛ 35. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ:*



*ДҮРСЛЭЛ 36. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*




*ДҮРСЛЭЛ 37. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 22:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 2-3 гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 38. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*



*Шигтгээ 23:*

*2025 оны байдлаар **30.0%** нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаа өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 24:*

*Тайлант хугацаанд **37.0%** нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 39. КОДЕКСИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН ЗҮЙЛЭЛТҮҮД:*




## 8.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН [§] *(Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодрууллав)*

| № | Компанийн нэрс | Үнэлгээ |
|---|---|---|
| 1 | "ҮНЭТ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 98.6% |
| 2 | "НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 94.4% |
| 3 | "АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 93.1% |
| 4 | "ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 93.1% |
| 5 | "МАНДАЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 91.7% |

[§] “Эм Эф Жи ассет менежмент” ХХК, “Зөв Статус Инвестмент” ХХК болон “Грөүт Капитал ассет менежмент” ХХК-ууд нь хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 онд авсан бөгөөд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайлангийн анхны нөхцөл байдлын үнэлгээг Хорооноос 2026 оны 2 дугаар улиралд багтаан хэрэгжилтийн тайланг ирүүлэх даалгавар өгөгдсөн.

| | | |
|---|---|---|
| 6 | "СИНЕРЖИ ФАНД СОЛЮШН ҮЦК" ХХК | 90.3% |
| 7 | "БАЛАНСЭД ГРӨУТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 87.5% |
| 8 | "АВАЛОН ИНВЕСТМЕНТС ҮЦК" ХХК | 84.7% |
| 9 | "АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 80.6% |
| 10 | "ИНВЕСКОР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 80.6% |
| 11 | "МАСТЕР ИНВЕСТМЕНТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 79.2% |
| 12 | "ЮНИТИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 76.4% |
| 13 | "ОЧУН ҮЦК" ХХК | 72.2% |
| 14 | "ТИ ДИ БИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 72.2% |
| 15 | "И ЭС ТИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 70.8% |
| 16 | "СОД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 70.8% |
| 17 | "СТЭПП МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 69.4% |
| 18 | "ТЕН ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК | 68.1% |
| 19 | "ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК" ХХК | 68.1% |
| 20 | "ЭН ЖИ КОМИТИ ҮЦК" ХХК | 68.1% |
| 21 | "ГОЛОМТ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 66.7% |
| 22 | "ГОЛОМТ ФАНД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 66.7% |
| 23 | "РАЙНОС ЭССЭТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 66.7% |
| 24 | "УЛААНБААТАР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 66.7% |
| 25 | "ОКАНЕ ХОЛДИНГС ҮЦК" ХХК | 63.9% |
| 26 | "УАН ПАРТНЕРС ҮЦК" ХХК | 63.9% |
| 27 | "ИХ ЧИНГИС ХААНЫ ХӨМРӨГ ҮЦК" ХХК | 62.5% |
| 28 | "ЭМ ЭФ ЖИ АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК | 62.5% |
| 29 | "БИ БИ ЭС ЭЙ ҮЦК" ХХК | 54.2% |
| 30 | "НЭЙШНЛ ФАНД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 50.0% |
| 31 | "ЗӨВ СТАТУС ИНВЕСТМЕНТ" ХХК | 48.6% |
| 32 | "ГРӨУТ КАПИТАЛ АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК | 47.2% |
| 33 | "ЭКСПОНЭЙШНЛ ФАНД МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 40.3% |
| 34 | "БЛАК СВОН ҮЦК" ХХК | 33.3% |
| 35 | "БАТ КАПИТАЛ МЕНЕЖМЕНТ ҮЦК" ХХК | 18.1% |

# 9. ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

*ДҮРСЛЭЛ 40. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ:*




*Шигтгээ 25:*

*Нийт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч* **10** *компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад үнэлгээ* **1.1** *нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.*

*ДҮРСЛЭЛ 41. "КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС"-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ:*




*Шигтгээ 26:*

*ТУЗ нь бизнесийн ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх, хувьцаа эзэмшигчийн эрхийг тэгш хангах зэрэг ажлуудыг хангалттай сайн зохион байгуулсан гэж үнэлэгдсэн бол ТУЗ-ийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллыг үйл ажиллагааны тайланд тусгах, оролцогч талуудтай харилцах, мэдээлэл солилцох, ТУЗ-ийн жилийн үйл ажиллагаа төлөвлөх, гүйцэтгэлийн үр дүнгээ үнэлэх зэрэг ажлууд хангалтгүй хийгдсэн байв*

*ДҮРСЛЭЛ 42. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН:*




*Шигтгээ 27:*

*Төлөөлөн удирдах зөвлөл нь 5-7 гишүүнтэйгээс 37.0% нь хараат бус гишүүд байна.*

*Шигтгээ 28:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 28.0% нь эмэгтэй.*

*ДҮРСЛЭЛ 43. ТУЗ-ИЙН ХУРАЛ:*

| Он | 2024 | 2025 |
|---|---|---|
| ТУЗ-ийн хурлын дундаж тоо | 4 | 5 |
| Хурлын дундаж ирц | 95% | 95% |
| Хэлэлцсэн асуудлын дундаж тоо | 9 | 12 |

*ДҮРСЛЭЛ 44. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):*




*ДҮРСЛЭЛ 45. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:*

**2024.IV**

- Хүйс-эмэгтэй дундаж -**73.3%**
- Мэргэжил-эрх зүйч дундаж - **33.3%**
- ТУЗ-ийн нарийн бичгийн даргын дундаж нас - **32**

**2025.IV**

- Хүйс-эмэгтэй дундаж - **75.8%**
- Мэргэжил-эрх зүйч дундаж - **34.0%**
- ТУЗ-ийн нарийн бичгийн даргын дундаж нас - **33**

*ДҮРСЛЭЛ 46. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ:*



*ДҮРСЛЭЛ 47. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:*




*ДҮРСЛЭЛ 48. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:*




*Шигтгээ 29:*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 2-3 гишүүнтэй.*

*ДҮРСЛЭЛ 49. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:*



*Шигтгээ 30:*

*2025 оны байдлаар 50.0% нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаа өөрийн цахим хуудсандаа байршуулсан.*

*Шигтгээ 31:*

*Тайлант хугацаанд 66.0% нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон.*

*ДҮРСЛЭЛ 50. КОДЕКСИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:*



## 9.1. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН *(Давтан үнэлгээ ирүүлсэн компанийг ногооноор тодруулав)*

| № | Компанийн нэрс | Үнэлгээ |
|---|---|---|
| 1 | "ИКС МЕТА" ХХК | 97.2% |
| 2 | "АНД ДЭНӨҮД" ХХК | 95.8% |
| 3 | "ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА" ХХК | 90.3% |
| 4 | "ПОВЕРЭД ЭЙ ДИ ЭМ" ХХК | 90.3% |
| 5 | "НЭЙШНАЛ ТРЭЙШИР БИТ СЕКЬЮРИТИ" ХХК | 84.7% |
| 6 | "ЧОЙЖИН АЛТЕКС" ХХК | 79.2% |
| 7 | "КОМПЛЕКС ДИЖИТАЛ ЭКОСИСТЕМ" ХХК | 75.0% |
| 8 | "АЙДАКС" ХХК | 70.8% |
| 9 | "КОЙН ХАБ" ХХК | 69.4% |
| 10 | "ЗООС ДИЖИТАЛ ЭКСЧЭЙНЖ" ХХК | 62.5% |
| 11 | "КОРЕКС" ХХК | 62.5% |
| 12 | "КАПЕКС КАПИТАЛ" ХХК | 43.1% |

**-oOo-**